

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**ТЕНДЕРИЙН НЭР: ЗҮТГҮҮРҮҮДИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ /2 БАГЦ/
ТЕНДЕРИЙН КОД: МРЦМ/ 20240101052**

Гүйцэтгэх техникийн засвар, үйлчилгээний ажил: “Монгол-Оросын ХННийгэмлэг Улаанбаатар төмөр замын даргын 2018 оны 3-р сарын 23-ны № А-124 тоот тушаалаар батлагдсан Илчит тэрэгний засварын журмын 2.1.3 заасны дагуу ТО-3, мөн журмын 2.1.4 заасны дагуу ТР-1 урсгал засварын тухай заалтын дагуух засвар, үйлчилгээний ажлыг Хэнтий аймгийн “Бор-Өндөр” суман дахь “МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ -ийн харъяа “Бор-Өндөр” УБҮ -ийн “Гадаад экспортод гарах бүтээгдэхүүн зөөвөрлөх”-д ашиглагдаж буй ТЭМ2У-1277 болон ТЭМ2У-9178 серийн илчит тэрэгнүүдэд ТО-3, ТР-1 үйлчилгээ, урсгал засварын ажлуудыг гүйцэтгэнэ.

БАГЦ №1 – ИЛЧИТ ТЭРЭГ №1277-д хийгдэх засвар, үйлчилгээ

Техникийн тухай мэдээлэл:

- Илчит тэрэгний модель/зориулалт/Үйлдвэрлэсэн улс: ТЭМ2У/Сэлгээний/ ОХУ
- Илчит тэрэгний үйлдвэрлэсэн он: 1986 он
- Илчит тэрэгний Ser No: *1277*
- Илчит тэрэгний ажиллах цаг: Сарын хугацаанд төлөвлөгөөгөөр 500 мотоцаг хүртэл

Техникийн тогтмол хийгддэг засвар үйлчилгээ: Ээлж бүрт ТО-1, ТО-2 долоо хоногт 1 удаа
ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГРАФИК 2024 ОНД

Огноо	I-улирал			II-р улирал			III-р улирал			IV-р улирал		
	Сар			Сар			Сар			Сар		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хийгдэх ажил				ТО-3		ТР-1			ТО-3			ТР-1

БАГЦ №2 ИЛЧИТ ТЭРЭГ №9178- д хийгдэх засвар үйлчилгээ

Техникийн тухай мэдээлэл:

- Илчит тэрэгний модель/зориулалт/Үйлдвэрлэсэн улс: ТЭМ2У/Сэлгээний/ ОХУ
- Илчит тэрэгний үйлдвэрлэсэн он: 1990 он
- Илчит тэрэгний Ser No: *9178*
- Илчит тэрэгний ажиллах цаг: Сарын хугацаанд төлөвлөгөөгөөр 500 мотоцаг хүртэл

Техникийн тогтмол хийгддэг засвар үйлчилгээ: Ээлж бүрт ТО-1, ТО-2 долоо хоногт 1 удаа
ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГРАФИК 2024 ОНД

Огноо	I-улирал			II-р улирал			III-р улирал			IV-р улирал		
	Сар			Сар			Сар			Сар		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хийгдэх ажил							ТО-3			ТР-1		

Техникийн тодорхойлолтын хавсралтууд:

Хавсралт №1. Илчит тэрэгний засварын журмын дагуу ТО-3 үзлэг үйлчилгээгээр хийгдэх ажилбарууд

Хавсралт №2. Илчит тэрэгний засварын журмын дагуу ТР-1 урсгал засвараар хийгдэх ажилбарууд

Хавсралт №3. Нэмэлт шаардлага /Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага, ажил гүйцэтгэх хугацаа/

Хавсралт №1. ИЛЧИТ ТЭРЭГНИЙ ЗАСВАРЫН ЖУРМЫН ДАГУУ ТО-3 ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ХИЙГДЭХ АЖИЛБАРУУД

“ТЭМ2 серийн илчит тэргэнд хийгдэх урсгал засварын дүрэм”-ийн ТО-3 үзлэг, үйлчилгээ засварын шаардлагын дагуу заагдсан ажлуудыг групп тус бүрээр бүрэн хийнэ. Үүнд: **Дизель, туслах тоноглолын группээр:**

- Дизелийн цилиндрүүдийн ажиллагааг шалгаж, цилиндрүүдийн шахалтын нягтыг шалгах
- Дизелийн тосны дээж авч анализ хийх
- Дизелийн картерт бүрэн үзлэг хийж, тосолгооны труба, хоолойн бэхэлгээ, шатуны болтны дөрний байдал, холхивчуудын байдалд үзлэг хийх
- Дизелийн тахир голын үндсэн хүзүүний холхивч, шатуны холхивчийн тосолгооны зайг хэмжих
- Дизелийн клапаны тосолгооны байдал болон тохируулага шалгах
- Дизелийн цилиндрүүдийн тагны чангалгааг хийж, клапан тохируулах
- Дизелийн цилиндрийн тагыг шаардлагатай бол бол өргөх.
- ТК-30 роторын чөлөөт эргэлт шалгаж, роторын хөдлөн гүйлт шалгах
- ТК-30 тосолгооны тройникиг авч шүүрийг цэвэрлэх
- Усны насосны сальникийн байдлыг шалгаж, шаардлагатай бол нэмэх
- Дизелийн хөргөлтийн шингэний дээжийг авч шинжлүүлэн шаардлагатай бол хөргөлтийн шингэнийг шинээр солих
- Маслын насосын дамжлагын бэхэлгээ, кардан голуудын холболтыг шалган чангалгаа хийх
- Маслын радиаторын байдлыг хаалттай секцийн үзлэг хийж дүгнэлт гаргах
- Газ хуваарилах нударган голын холболтын фланец бэхэлгээ болон дөрний байдлыг шалгах
- Кардан дамжлагуудын тосолгоо хийнэ

Түлш шүүрийн группээр:

- Бүх шүүрүүдийг авч цэвэрлэнэ.
- Түлшний нударган голын холболтын бэхэлгээ, дөрний байдлыг шалгана
- Түлшний аппарат тосолгоо, холхивчийн байдлыг шалгана
- Эргэлтийн тоо тохируулагчын гадна үзлэг хийж, ломбоны байдлыг магадлан шалгана
- Түлшний өндөр нам даралтын хоолойн бэхэлгээг шалгана.
- Түлшний туслах насосын ажиллагааг, одон холбооны байдлыг шалгана.

Автоматын группээр:

- Машинчийн кран 394, туслах тормозын краны золотник тослон ажиллагааг шалгах
- КТ-6 хуудсан холбоог шалган чангалгааг хийх.
- КТ-6 бүтээмж шалгах.
- Агаар хуваарилагчийн ажиллагааг шалгах.
- Агаарын зөөлөн холбооны байдлуудыг шалгах.
- ЗРД-ийн ажиллагааг шалгах.
- Агаарын нөөц савнуудын гадна үзлэг хийх.

Кип, нарийн хэмжүүрийн группээр:

- Бүх хэмжих хэрэгсэлд үзлэг хийх
- СЛМ-3 хурд хэмжигчийг авч стэнд дээр шалган баталгаажилт хийж ломбодох
- ЭПК-150И ажиллагааг шалгах

Цахилгаан тоноглолын группээр:

- Бүх цахилгаан хэлхээний бэхэлгээг шалгах
- Цахилгааны өндөр нам хүчний хэлхээний тусгаарлагчийн эсэргүүцлийг шалгах
- Бүх цахилгаан машины холхивчийн тосолгоог шалгаж шаардлагатай бол нэмэх
- Бүх цахилгаан машины цэвэрлэгээг хийх
- Бүх цахилгаан тоноглолын ажиллагааг шалгах, ажиллагааны эрэмбэ дарааллыг шалгах
- Газардлагын реле, галын дохиоллын ажиллагааг шалгах
- Аккумуляторын шингэний түвшинг шалгаж шаардлагатай бол нэмэх
- Бүх гэрэлтүүлгийн байдлыг шалгах
- Цахилгаан машинуудын хөргөлтийн сэнс, түүний холхивчийн байдлыг шалгах
- Ерөнхий генераторын хуудсан холбооны бэхэлгээг шалгаж чангалах

Цахилгаан явах ангийн группээр:

- Явах ангид гадна бүрэн үзлэг хийнэ
- Хос дугуйн бүрэн үзлэг хийж, жийрэг мөөрөнд ТАД-ад заасан хэмжээнээс илүү гарсан хортон, чирэг үүссэн, дэлний босоо элэгдэл үүссэн эсэхэд үзлэг хийнэ.
- Хос дугуй, мал зайлуулгын хэмжилт хийж, шаардлагатай бол хос дугуйн зоролт хийх.
- Мотор голын холхивчийн тосны түвшинг шалгах
- Явах ангийн бүх чангалгааг хийж дөрний байдлыг шалгана
- Тормозын цилиндрийн шилбэний тохируулга хийнэ
- Бүх татах цахилгаан хөдөлгүүрийн араан дамжлагын тосолгоо нэмнэ
- Авто угсрааг салган авч бүх хэмжилт хийж баталгаажуулна
- Татах цахилгаан мотор, хөтлөх төхөөрөмжид гадна үзлэг хийнэ

Хавсралт №2. ИЛЧИТ ТЭРЭГНИЙ ЗАСВАРЫН ЖУРМЫН ДАГУУ ТР-1 УРСГАЛ ЗАСВАРААР ХИЙГДЭХ АЖИЛБАР

ТР-1 ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ: Илчит тэрэгний түргэн элэгддэг болон хүнд ачаалалтай эд ангиудыг хянах, дизель, цахилгаан машин болон аппаратууд, явах анги, туслах тоноглол, зүтгүүрийн системүүдийн эд ангиудын байдал, ажиллах чадварыг шалгах, засварын зааварт заагдсан шаардлагын дагуу илчит тэргэнд хяналтын туршилт хийж тохируулах ажилбаруудыг хийж гүйцэтгэх. **Үүнд:**

Дизель, туслах тоноглолын группээр:

- Дизелийн цилиндрүүдийн ажиллагааг шалгаж, цилиндрүүдийн шахалтын нягтыг шалгах
- Дизелийн тосны дээж авч анализ хийх
- Дизелийн картерт бүрэн үзлэг хийж, тосолгооны труба, хоолойн бэхэлгээ, шатуны болтны дөрний байдал, холхивчуудын байдалд үзлэг хийх
- Дизелийн тахир голын үндсэн хүзүүний холхивч, шатуны холхивчийн тосолгооны зайг хэмжих
- Дизелийн клапаны тосолгооны байдал болон тохируулага шалгах
- Дизелийн цилиндрүүдийн тагны чангалгааг хийж, клапан тохируулах
- Дизелийн цилиндрийн тагийг шаардлагатай бол өргөх
- ТК-30 роторын чөлөөт эргэлтийг шалгаж, роторын хөндлөн гүйлт шалгах
- ТК-30 тосолгооны тройник авч шүүрийг цэвэрлэх
- Усны насосын сальникийн байдлыг шалгаж, шаардлагатай бол нэмэх

- Дизелийн хөргөлтийн шингэний дээжийг авч шинжлүүлэн шаардлагатай бол хөргөлтийн шингэнийг шинээр солих
- Маслын насосын дамжлагын бэхэлгээ, кардан голуудын холболтыг шалган чангалгаа хийх
- Хөргөлтийн шингэн, маслын секцийн байдлыг хаалттай секцийг солих
- Газ хуваарилах нударган голын холболтын фланец бэхэлгээ болон дөрний байдлыг шалгах
- Кардан дамжлагуудын тосолгоо хийх

Түлш шүүрийн группээр:

- Дизелийн форсункуудыг авч стенд дээр шалгаж, шаардлагатай бол засварлах арга хэмжээ авч тохируулага хийж ломбодох
- Бүх шүүрүүдийг авч цэвэрлэх
- Түлшний нударган голын холболтын бэхэлгээ, дөрний байдлыг шалгах
- Түлшний аппаратын тосолгоо, холхивчийн байдлыг шалгах
- Эргэлтийн тоо тохируулагчийн гадна үзлэг хийж, ломбоны байдлыг магадлан шалгах
- Түлшний өндөр нам даралтын хоолойн бэхэлгээг шалгах
- Түлшний туслах насосын ажиллагааг, одон холбооны байдлыг шалгах

Цахилгаан тоноглолын группээр:

- Бүх цахилгаан хэлхээний бэхэлгээг шалгах
- Цахилгааны өндөр нам хүчний хэлхээний тусгаарлагчийн эсэргүүцлийг шалгах
- Бүх цахилгаан машины холхвчын тосолгоог шалгаж шаардлагатай бол нэмэх
- Бүх цахилгаан машины цэвэрлэгээг хийх
- Бүх цахилгаан тоноглолын ажиллагааг шалгах, ажиллагааны эрэмбэ дарааллыг шалгах
- Газардлагын реле, галын дохиоллын ажиллагааг шалгах
- Батерийн шингэний түвшинг шалгаж шаардлагатай бол нэмэх
- Бүх гэрэлтүүлэгийн байдлыг шалгах
- Цахилгаан машинуудын хөргөлтийн сэнс, түүний холхивчийн байдлыг шалгах
- Ерөнхий генераторын хуудсан холбооны бэхэлгээг шалгаж чангалах

Автоматын группээр:

- Машинчын кран 394, туслах тормозын краны золотник тослон ажиллагааг шалгах
- КТ-6 хуудсан холбоог шалган чангалгааг хийх
- КТ-6 бүтээмж шалгах
- Агаар хувиарлагын ажиллагааг шалгах
- Агаарын зөөлөн холбооны байдлуудыг шалгах
- ЗРД-ийн ажиллагааг шалгах
- Тормозын цилиндрүүдийн манжет тослох
- Агаарын нөөц савнуудын гадна үзлэг хийх

Кип, нарийн хэмжүүрийн группээр:

- Бүх хэмжих хэрэгсэл салган авч тусгай стенд дээр шалган баталгаажилт хийх
- СЛМ-3 хурд хэмжигчийг авч стенд дээр шалган баталгаажилт хийж ломбодох
- ЭПК-150И ажиллагааг шалгах

Цахилгаан, явах ангийн группээр:

- Явах ангид гадна бүрэн үзлэг хийх.
- Хос дугуйн бүрэн үзлэг хийж, жийрэг мөөрөнд ТАД-ад заасан хэмжээнээс илүү гарсан хортон, чирэг үүссэн, дэлний босоо элэгдэл үүссэн эсэхэд үзлэг хийх /Шаардлагатай зоролт хийх/
- Хос дугуй, мал зайлуулагын хэмжилт хийж, шаардлагатай бол хос дугуйн зоролт хийх.

- Хос дугуйн буксны тулгуурын байдалд үзлэг хийж тос солих.
- Мотор голын холхивчуудын байдал үзлэг, хэмжилт хийх.
- Явах ангийн бүх чангалгааг хийж дөрний байдлыг шалгах.
- Тормозын цилиндрийн шилбэний тохируулага хийх.
- Бүх татах цахилгаан хөдөлгүүрийн якорийн холхивчийн тосолгоо хийх.
- Бүх татах цахилгаан хөдөлгүүрийн араан дамжлагын тосолгоо нэмэх.
- Авто угсрааг салган авч бүх хэмжилт хийж баталгаажуулах.
- Татах цахилгаан мотор, хөтлөх төхөөрөмжид гадна үзлэг хийх.
- ТЭМ2 серийн урсгал засварын дүрэм-д заагдсны дагуу ТР-1 засвараар гарч бэлэн болсны дараа дизель- генераторын бүх параметрийг шалгах зорилгоор реостатын туршилт хийх.

Хавсралт №3. Нэмэлт шаардлага /Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага, ажил гүйцэтгэх хугацаа/

ТО-3 БОЛОН ТР-1 УРСГАЛ ЗАСВАР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

1. Тусгай зөвшөөрөл: Зүтгүүр, түүний эд ангийг засварлах” тусгай зөвшөөрөлтэй байх
2. Мэргэжлийн өндөр зэрэгтэй, дадлага туршлагатай засварчид, инженер техникийн ажилтантай байх
3. Эд ангиудын баталгаажилт хийх, ТР-1 засварын дараа реостатын товчилсон туршилт хийх, мөн хос дугуйнуудыг зорох зэрэг шаардлагатай тохиолдолд ТЭМ2-1277 ба ТЭМ2- 9178 дугаар бүхий зүтгүүрүүдийг Улаанбаатар зүтгүүрийн депод засуулах.
4. ТР-1 урсгал засвараас дараагийн төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үйлчилгээ хүртэл ашиглалтын баталгааг гаргана.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

1. Ажлыг гэрээнд заасан хийгдэх засварын ажлын графикийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. Төлөвлөгдсөн засвар, үйлчилгээний ажил гүйцэтгэх хуваарьт хугацаа нь тухайн зүтгүүрийн ажлын ачааллаас шалтгаалан өдөр, хоног өөрчлөгдөж болно.
2. Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 14 хоногийн дотор голлох мэргэжилтнүүдийг ажлын талбайд ажиллуулах хөтөлбөр, хуваарийг гаргаж батлуулна.
3. Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. Хийгдсэн ажлыг илчит тэрэгний техникийн холбогдох паспортуудыг бөглөж, гүйцэтгэлийг акт үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулснаар ажлыг гүйцэтгэсэнд тооцно.
4. Хийгдсэн ажлыг илчит тэрэгний техникийн холбогдох паспортуудыг бөглөж, гүйцэтгэлийг акт үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулснаар гүйцэтгэсэнд тооцно.